

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Мягмар	Дугаар	L291
Оршин суугаа аймаг	Хөвсгөл аймаг	Оршин суугаа сум	Тосонцэнгэл
Төрсөн газар	Тосонцэнгэл сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Ловон лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Баянголын хүрээ	Сүм хийдийн дугаар	ХӨТЦ 061
Одоогийн сүм хийд	Гандандамчойлин хийд	Сүм хийдийн дугаар	ХӨТЦ 016
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны6-р сарын19	Ярилцлага авсан хүн	Д .Мөнхбат



Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Баянголын хүрээ, Гандандамчойлин хийд

Мөнхбат: Тэгэхээр энэ Тосонцэнгэл сумын нутагт академич Ренчин гуайн судалгаа бүртгэл жагсаалтаар тухайн үеийн Засагт хан аймгийн Ахай бэйсийн хошууны одоо дэд багийн хүрээ, Баянголын хүрээ гэж одоо ийм хүрээ орсон байдаг. Тэгэхээр өнөөдрийн энэ Тосонцэнгэл сумын төв дээр байгуулагдсан Гандандамчойлин хүрээ бол яг одоо энэ Ахай бэйсийн хүрээний одоо Баянголын хүрээ гэж нутгийн олондоо алдаршсан энэ хүрээний одоо туурь буурин дээр байгуулагдаж одоо өөрөөр хэлвэл одоо тэр сэргээж, буян номынх нь үйл ажиллагааг үргэлжлүүлж байгаа ийм хүрээ юм байна. Тэгэхээр та одоогоос тэр хоёр зуугаад шахуу жилийн тэртээ үүсч байгуулагдаж бурхан номын үйл ажиллагааг түмэн олондоо хүртээж явсан энэ хошуу нутгийн томоохон хүрээ хийд болох Баянголын хүрээний тухай танаас одоо ингэж ярилцлага авъя гэж бодож байна.Тэгэхээр энэ хүрээ яг хэдэн онд байгуулагдсан байх нь вэ?

Мягмар: 1805 онд байгуулагдсан гэдэг юм.

Мөнхбат: За 1805 онд. Тэгэхээр энэ яг туурин дээр байсан юм болов уу, анх хаана байсан юм бол ?

Мягмар: Энэ буурин дээрээ.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Мөнхбат: Энэ буурин дээрээ?

Мягмар: Энэ чинь жүдийн дуганы буурь. Тийм манай багш хэлж байсан.

Мөнхбат :Энэ хүрээ байгуулагдсан тэр үед одоо шашин номынхоо яг ид мандан бадралынхаа үед одоо ид хөгжлийнхөө өндөр түвшинд гэсэн үг ш дээ, тийм ээ. Байж байхдаа за одоо хичнээн ламтай, ямар ямар шашны зан үйл хийдэг, за ямар ямар сүм дугантай ийм хүрээ хийд байсан юм бол оо?

Мягмар: Гурван зуугаад ламтай, тэгээд энэ шашны таван ухааны юутай байсан гэсэн. Жүдийн дацан, дүйнхорынх, мамба ...

Мөнхбат: Зурхай?

Мягмар: Зурхай...

Мөнхбат : Сахиусны дуган?

Мягмар: Тийм, сахиусны дуган. Тэгээд диваажингийн дуган гэж тийм байсан юм гэнэ лээ.

Мөнхбат: Гурван зуугаад ламтай?

Мягмар: Тийм, гурван зуугаад ламтай, хуврагтай.

Мөнхбат: Энэ хүрээний үүх түүхтэй нэр нь холбогдсон, шашны таван ухаанд мэргэшсэн нутаг хошуундаа алдартай том том хутагт хувилгаад байсан л байх даа? Та зарим нэгэн жишээ хэлээч?

Мягмар: Жишээлбэл хутаг Билэгдэмбэрэл гуай гэдэг хүн байсан юм гэнэ лээ. Жалханз хутагтын буюу Очирваань бурхны хувилгаан. Очирваанийн хувилгаан байсан хүн.

Мөнхбат: Энэ хүрээний одоо анхны хамбыг та мэдэх үү, одоо түүх номонд ямар хүн байсан юм бол?

Мягмар: Би мэдэхгүй байна аа.

Мөнхбат: Сүүлчийн хамба нь?

Мягмар: Сүүлчийн хамбыг нь одоо мэдэхгүй. Би сайн мэдэхгүй байна.

Мөнхбат: За энэ хүрээний одоо шүтээн сахиус?

Мягмар: Тайг чойжил гэдгийн Хар морьт сахиус, номын хаан.

Мөнхбат: Ямар чойжил оо?

Мягмар: Тайг чойжил.

Мөнхбат: Хар морьт сахиус, номын хаан?

Мягмар: Тийм, номын хаан.

Мөнхбат: Одоо энэ хүрээ өнөөдөр ер нь хүрээний туурин дээр шинээр баригдсан шинэ одоо энэ хийдийн бас л гол одоо үндсэн сахиус байгаа юу?

Мягмар: Тийм. Энэ бол Ахай бэйсийн хошууны гол шүтээн байсан гэдэг юм билээ.

Мөнхбат: Ахай бэйсийн хошууны гол шүтээн байсан?

Мягмар: Тийм.

Мөнхбат :Харин одоо энэ шүтээн цэвүүн цагийн үед яаж одоо ингэж устаж алга болчихгүй шиг явсаар байгаад өнөөдөр энэ танай хийдэд үе дамжин ирээ вэ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Мягтар: Энэ сайн сэтгэлтэй улсууд нь нуусаар байгаад тэгээд усан дотор ч, мөсөн дотор ч аргал дотор ч нуусаар байгаад тэгээд сумаа л тойрч байсан.

Мөнхбат: Сумаа л тойрсон?

Мягмар: Тийм, сумаа л тойрч байгаад тэгээд...

Мөнхбат: Сумын хошуу нутгаас бол гаргаагүй?

Мягмар: Гаргаагүй. Мөрөнгийн хийд байгуулагдах дээр очсон юм шүү, сүүлд байгуулагдахад нь.Тэгээд тэнд очоод жаахан тааламжгүй болоод гал мал идээд гэр орон нь.Тэгээд наашаа дөхөөд, бид нар энэ наашаа залж, энэ хуучин байсан газар нь залаад тэгээд дуган барьж өгсөн тийм учиртай байгаа юм.

Мөнхбат: Тэгэхээр одоо нэг ийм яриа юу орёе л доо.1937, 1938 оны үед одоо цөвүүн цаг эхэлж тийм ээ, бурхан номоо устгаж үгүй хийж одоо тэр шашны өндөр их боловсролтой, ийм одоо мэргэшсэн лам нараа барьж устгаж, дунд доод лам нарыг хүчээр хар болгож алба татварын бодлогоор ингэж чангалж сүм хүрээ хийдийг эзгүйрүүлсэн.За үүний зэрэгцээ мөн одоо бурхан тахил судар номыг үгүй хийж устган галдан шатаах ажил манай одоо бүх хүрээ хийдэд ийм гашуун хувь заяа тохиосон.Тэгэхээр энэ Гандандамчойлин хийдийн хувь заяа ер нь тэр үед ямар байсан юм бол оо, та энэ талаар ер нь ямар мэдээлэлтэй байна вэ? Энэ одоо лам нарыг нь баривчлаад, хүчээр хар болгочихоод сүм дуганыг нь галдан шатааж устгасан юм уу, эсвэл сүм дуган эзгүйрчихээд нэг хэдэн жил болоод, магадгүй дөчөөд оны нүүрийг үзээд, дөчөөд оны дунд үеийг үзээд ингээд одоо буулгагдсан юм болов уу, энэ одоо яасан юм бол оо?

Мягмар: Энэ ер нь хүний үр гэдэг чинь хар цагаан хоёрын үйлийн үр байдаг юм. Тэр үйлийн үрийн боловсролоор л тэр цагтаа устгах цагтаа устсан байх гэж бодож байгаа.Түүнээс биш тэр нурааж байгаа улсын буруу биш, алж хядаж байгаа улсын буруу биш, алагдаж байгаа улсын ч буруу биш. Энэ үйлийн үрийн боловсроол байхгүй юу.Үйлийн үр нь боловсорч тэр цаг нь болохоор тийм ээ, нэг мөхөх ёстой, нэг нь сэргэх ёстой. Үйлийн үрийн хар цагаан үйлийн үрийн энэ юу байгаа.

Мөнхбат: Тэгэхээр одоо лам нарыг нь барьж авчихаад сүм дуганыг нь шууд шатаачихсан уу, эсвэл энэ сүм дуган нь байсан юм болов уу, хэсэг хугацаанд?

Мягмар: Байсан юм гэнэ лээ. Байшин захиргаа энэ тэрээс л юу энэ тэр орж байсан юм гэсэн. Байшин бариад, тэгээд хувь хүнд өгөх нь өгч байсан гэж байсан байгаа юм.

Мөнхбат: Аа бас айлуудад айлын амбаар пүнз болоод явж байсан?

Мягмар: Амбаар пүнз болоод явж байсан юм гэнэ лээ.Заримыг нь тэр Рашаант руу ч ачуулж байсан гэсэн.

Мөнхбат: Тухайн үед нь яг эзгүй болонгуут нь шууд устгачихаагүй юм байна, тийм ээ?

Мягмар: Устгачихаагүй юм.

Мөнхбат: Эхлээд лам нарыг нь байхгүй болгочихоод дараа нь хэдэн жилийн дараа?

Мягмар: Тийм, эхлээд лам нарыг нь хоморголж барьж байгаад, манай энд чинь ардын хөдөлгөөн гарсан ш дээ.

Самбаадүвчин тэргүүнтэй.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Мөнхбат: 1932 оны одоо түрүү үеийн түүхэнд бол хувьсгалын эсэргүү гэдэг, одоо шинэ цагийн түүхэнд бол лам нарын хөдөлгөөн гэж яриад байгаа ш дээ, ардын хөдөлгөөн гэж байгаа тийм ээ?

Мягмар: Тийм, тийм.

Мөнхбат: Энэ ардын хөдөлгөөний томоохон бас бүс нутаг байсан л даа?

Мягмар: Мөн.

Мөнхбат: Яах аргагүй одоо энэ Сэлэнгэ мөрнийг дагасан ард тал, урд талын сав нутаг тийм ээ?

Мягмар: Тийм.

Мөнхбат :Одоо төв нь бол одоогийн Хөвсгөл аймгийн Рашаант сум буюу тухайн үеийн одоо Мэргэн гүний хошуу шүү дээ. Аргагүй л одоо, энэ хөдөлгөөнд нэлээн?

Мягмар: Гол жанжин манай Самбуу жанжин. Самбуудувчин одоо манай Асгатад төрсөн хүн байгаа юм. Манай эндхийн хүн.

Мөнхбат :Та их бахархаж байна уу?

Мягмар: Бахархалгүй яахав./ инээв /

Гандандамчойлин хийд

Мөнхбат: За өнөөдөр 2007 оны 6 сарын 19-ны өдөр. Судалгааны багийн судалгааны ажил Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумаас үргэлжлэн явагдаж байна аа. Манай судалгааны баг өнөөдөр Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын төвийн урд хэсэгт байрлах хуучин Засагт хан аймгийн Ахай бэйсийн хошууны одоо бурхан номын томоохон газрын нэг Баянголын хүрээний туурин дээр баригдаж сэргээгдсэн энэ Гандандамчойлин хийдийн гол одоо цогчин дуганаас энэ ярилцлагыг хийж байна аа. Тэгэхээр энэ Гандандамчойлин хийдийн гол цогчин дуган нь бол одоогоос хоёр зуугаад жилийн тэртээ энэ нутагт энэ одоо Баянголын хэмээх уудам цэлгэр хөндийд байж байсан Баянголын хүрээний жүдийн дуганы туурин дээр сэргээгдэн байгуулж 1990 оноос хойш Гандандамчойлин хийд нэрээр үйл ажиллагаа явуулж байгаа. Энэ үйл ажиллагаагаараа Тосонцэнгэл сумын сүсэгтэн ард олонд одоо бурхан номын үйлчилгээ үзүүлж байгаа ийм сайхан бурхан номын газар байна аа. За ингээд бид нар Гандандамчойлин хийдийн ловон лам Мягмар гуайгаас дараах асуултыг тавьсан юм. Тэгэхээр та 1990 он буюу цагаан морин жилийн намрын эхэн сарын хорьдын орчим буюу 1990 оны наймдугаар сарын сүүлчээр энэ дуган маань хурал номын ажил сэргэж ингэж одоо манай шинэ цагийн Гандандамчойлин хийдийн түүх бичигдэж эхэлсэн гэж өгүүлж байсан. Тэгэхээр энэ одоо энэ арван долоон жилийн тэртээгээс энэ Гандандамчойлин хийдийн одоо шинээр байгуулагдаж байсан тэр цаг үеийг одоо эргэн дурсвал ямар байдаг юм, ямар ямар хүмүүс одоо гол гол үүргийг гүйцэтгэж байсан юм, одоо энэ дуган шууд ингээд байсан юм уу, эсвэл одоо өөр газар, өөр орчин нөхцөлд хүрж эхэлсэн юм уу, анхны лам нар нь одоо ямар ямар хүмүүс байсан юм, яаж одоо энэ бурхан тахилаа хуучны уламжилж одоо олж авч ингэж дэг жаягийн дагуу ингэж хийдийн ажил эхэлж байсан бэ, энэ талаар та хууч ярихгүй юу?

Мягмар: Би чинь одоо ярих гээд чадахгүй болчихоод байна ш дээ. Энэ хийд 1992 онд дуганаа барьж эхэлсэн юм.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Мөнхбат: Ерэн хоёр оноос өмнө бол гэрт хурж байсан?

Мягмар: Ерэн хоёр оноос өмнө бол гэрт хурж байсан. За дөрөв, таван лам хурж байсан байх. Манай багш байсан, Ду багш байсан, би байсан, Пүрэвжав гэж өвгөн байсан.

Мөнхбат: За анхны хурал бол ямар хурал хурж байв, ямар ном хурж байв?

Мягмар: Анх яахав дээ, одоо цогчин л хурж байсан. Номын чидав энэ тэр гээд л цөөхөн ном хурж байсан. Багш их номоор яахав гээд, одоо тэгээд хүчрэхгүй гээд.

Мөнхбат: Тухайн үед 1990-ээд онд бурхан шашин дахин дэлгэрч байх үед сум орон нутгийн одоо удирдлагууд төр засгийн байгууллагууд, сүсэгтэн олон та бүхэнд хэр одоо нааштай хандаж одоо жанлав өглөг хандив нэмэр болж байв даа?

Мягмар: Тухайн үед бид нар одоо хөөцөлдөж ярьж байгаад тэр ардчилсан холбоо энэ тэрээр ярьж байгаад, холбооныхонтой ярьж байгаад тэр чинь улстөржсөн үе байсан ш дээ. Тэгээд ярьж байгаад хурлынхан тэр хурлынхан байсан. Тэгээд тэр сумын хурлынхантай ярьж байгаад энэ модыг бол үнэгүй авч байсан юм. Би өөрөө явж авч байсан юм.

Мөнхбат: Одоо энэ дуган барьсан модыг?

Мягмар: Тийм, би зүсүүлж авч байсан юм. Араамтай байсан юм, манайх. Тэгээд энэ боссон юм.

Мөнхбат: Тэгээд энэ бол 1992 оны үйл явц уу?

Мягмар: Ерэн хоёр оны үйл явц. Би өөрөө Мөрөнд хурж байсан хүн, тэгээд завсар чөлөөнд нь бас ирээд. Тийм сахил тэнд л байсан, тэр үед.

Мөнхбат: Тэгэхээр энэ Ахай бэйсийн хошууны Сэлэнгэ нутгийн бурхан номын гол шүтээн байсан Баянголын хүрээний үе дамжсан одоо Хар морьт хэмээх энэ шүтээн сахиусыг танай хийд өнөөдөр ингээд үе залгамжилж явж байгаа юм байна аа. Тэгэхээр энэ одоо бурхан шашнаа ад үзэж байсан тэр цөвүүн цаг буюу далаад жилийн хугацаанд энэ хаана байж байгаад, ингээд бүрэн бүтнээрээ байж байгаад танайд одоо эсэн мэнд ирэв ээ, тахил зул нь тасарсан уу, ер нь ямар байдалтай байсан юм бэ?

Мягмар: Энэ болвол энэ сумынхаа төвөөс холдоогүй сахиус ш дээ.

Мөнхбат: Тийм үү?

Мягмар: Тийм, энэ айлаас айл дамжаад л ингээд л энэ хөгшчүүл, их олон хөгшчүүл дамжсан гэсэн. Би ч одоо заримыг нь мэдэхгүй. Хамгийн сүүлд энэ Гонгор гуай гэж хүн байсан. Сүүлд нь Нацаг гэж миний шавь байсан. Тэр өвгөн тэгээд тэрнээс л наашаа ирээд энэ Мөрөнд залагдаад, бид нар Мөрөнд аваачиж өгөөд. Тэгээд л дахиад эндээ авчраад тэгээд дуган хийдийг нь босгож өгөөд л тэгээд сахиусныхаа дуганд залчихсан байгаа, ийм л түүхтэй ш дээ.

Мөнхбат: За өнгөрсөн хугацаанд, энэ арван долоон жил гэдэг бас багагүй хугацаа. Тэгэхээр энэ хугацаанд сүм хийдийнхээ лам нар, боловсон хүчнийхээ мэдлэг боловсрол, шашны боловсролыг нь дээшлүүлэх одоо ламаар бэхжүүлэх гэдэг юм уу, тийм ээ. Одоо боловсон хүчнээр бэхжүүлэх тэд нарыг тогтвор суурьшилтай ажиллуулах талаар сум орон нутаг сүсэгтэн олон, ер нь танай хийд ямар бодлого баримталж байна вэ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Мягмар: За хөдөө газрын хийд бол одоо хэцүү байдаг юм ш дээ. Жандаг, энэ чинь улс цөөхөнтэй.Гэхдээ сүжигтэй хүүхдүүд, орох хүсэлтэй хүүхдүүдийг нь оруулдаг юм, бид нар. Тэгээд одоо гурав , дөрвөн хүүхдэд. Хоёр шашны их сургуульд байгаа.

Мөнхбат: Шашны их сургуульд?

Мягмар: Тийм, сургуульд.

Мөнхбат: Сурж байгаа?

Мягмар: Тийм, хоёр нь байгаа, нэг өвгөн байгаа.

Мөнхбат: Одоо лам нартаа бол зэд мэд гэсэн юм одоохондоо байхгүй?

Мягмар: Одоохондоо өгнө өө.

Мөнхбат: Аа бас өгөх үү?

Мягмар: Манай хийд хамаг амьтны тусын тулд одоо манай төлбөр цөөхөн ш дээ. Ердөө ямар ч ном уншсан хоёр зуун төгрөг.Тийм, бид нар бол шуналын төлөө биш. Бид нар бол мал аж ахуйтай улс, бид нар болоод л байна. Түслах аж ахуйтай байдаг юм.

Мөнхбат: Буяны л төлөө?

Мягмар: Тийм, буяны төлөө л явж байдаг улс шүү дээ. Тэгээд орсон жандагаа бол хувааж авна. Тэгэхдээ бас энэ чинь хийд орноо, энэ чинь бүхэл бүтэн айл юм шүү дээ.Тэгээд л бүх л юм хэрэг болно ш дээ. Түлээ түлш, тэгээд л бүх юм. Даанч одоо мөнгө төгрөгний боловсрол их дутагдаж байгаа ш дээ.

Мөнхбат: Тэгээд л одоо ерөөсөө сэтгэлээрээ л явж байгаа?

Мягмар: Тийм, сэтгэлээрээ л явж байгаа ш дээ. Хөдөөгийн хийдүүд бол, зарим хөдөөгийн хийдүүд бол бараг үүдээ хаачихсан хийд зөндөө байгаа ш дээ.

Мөнхбат: Үгүй ээ бид нар одоо Хөвсгөл аймгийн арван долоон сумаар явж байна. Сүүлийн хориод хоногт, одоо нэг гураван сүм дутуу байна. Явсан сумууд дотор яг одоо лам нартаа зэд өгөөд байнгын үйл ажиллагаа явуулж байгаа ганц хоёр л сум байна. Аа мөн одоо бүр үүдээ хаачихсан , ганц хоёр лам л үлдчихсэн. Тэд нар нь тусдаа одоо амь амиа борлуулаад гэр гэрээрээ үйлчилгээ үзүүлээд явж байгаа тийм чиг газар явж байна.Ингээд бид нарыг өнөөдөр ирэхэд яг одоо ингээд гурав дөрвүүлээ өнөөдхийнхөө хурлыг хийгээд ингээд байж байгааг бодоход бол танай хийд ингээд бас та бүгдийн сэтгэл зүтгэл эндээс бас харагдаж байна аа гэж одоо бид нар ойлгож байна. За танаас дараачийн асуултыг асууя, бас.Энэ сүм хийдийг одоо ингээд хөдөө орон нутагт барьж байгуулахад төр захиргааны байгууллага одоо ер нь хэр дэмжиж байна вэ, тухайн орон нутгийн?

Мягмар: Тухайн орон нутгийн тэр энэ тэр тэр тэрүүнийг барьж байгаа тэр нөхдүүдийн сэтгэлээс болно.Тэр сүжигтэй, сэтгэлтэй амьтанд буян үйлдье гэсэн сэтгэлтэй бол тэр нинжин сэтгэлтэй бол тэр улсад тусална.Аа үгүй, өшөө нөгөө эсрэг сэтгэлтэй болвол, амиа бодсон бол аминчхан үзэлтэй болвол тэр хэзээ ч тус болж чадахгүй ш дээ.

Мөнхбат: Танай сумын тухайд ямар байдаг юм?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Мягмар: Манайхан бол ер нь аминчхан үзэлтэй улсууд их шүү. Их төвөгтэй, биеэ гэсэн хүмүүжилтэй. Минийх гэсэн үзэлтэй.

Мөнхбат: Уг нь бол үндсэн хуулинд байгаа ш дээ, тийм ээ. Одоо төр нь шашнаа хүндэлнэ, шашин нь төрөө дээдэлнэ гэж?

Мягмар: Тийм.

Мөнхбат: Тийм нэг том зарчим бий ш дээ, тийм ээ?

Мягмар: Тийм.

Мөнхбат. За ингээд Ахай бэйсийн хүрээний Баянголын одоо энэ уудам хөндийд хоёр зуугаад жилийн тэртээ байсан, тэр гурван зуугаад лам хурж байсан, тэр том хүрээний буурь туурин дээр үйл ажиллагаагаа явуулж байгаа энэ танай хийдийн хамт олон лам нар хуваргууд энэ бүхэнд одоо ингээд энэ бүс нутаг сүсэгтэн олныхоо одоо буяны ариун мөрөөр үйлчлэх тэр сайхан үйлс чинь өлзийтэй байхын ерөөлийг дэвшүүлье. Таны өгсөн мэдээлэл манай судалгааны багийн ажилд үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна аа. За баярлалаа, таньд.